2	Хадны зураг, бичгийн дурсгал			
3	Булш оршуулгын дурсгал			
4	Тахил тайлгын байгууламж			
5	Барилга архитектурын дурсгал	2		
6	Хөшөө дурсгал			
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	2		2
6.Ховд Их сургууль				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар			
2	Хадны зураг, бичгийн дурсгал		6	
3	Булш оршуулгын дурсгал	4	39	
4	Тахил тайлгын байгууламж	1	7	
5	Барилга архитектурын дурсгал			
6	Хөшөө дурсгал		1	
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	5	53	58
	НИЙТ ДҮН	985	522	1859

Үл хөдлөх дурсгал алга болсон, эдвэрсэн, зөөгдсөн тухай мэдээ Булган, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд, Хэнтий аймгуудаас нийт 108 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд,

- Булган аймаг: Баяннуур сумын Цохын булан хэмээх газар орших чулуун дурсгалыг эртний Пугу аймгийн нэрт жанжны гэрэлт хөшөө хэмээн СӨҮТ-ийн мэдэгдсэнээр аймгийн музейд зөөвөрлөн авчирч байршуулсан.
- Сүхбаатар аймаг: Алаг морьтын хүн чулууг байсан газраас нь зөөвөрлөх оролдлого хийсэн байдалтай байсан учир иргэд санаачлагаараа

зөөвөрлөсөн. Асгат сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019,10,16 ны өдрийн 32 тоот тогтоолоор тээвэрлэсэн болно.

- Ховд аймаг: Улаан дэвсгийн хүн чулуу гэмтэлтэй болохыг Манхан сумын ЕБС-ийн багш Ц.Мөнхбат, Ч.Энхтөр нар мэдээлсэн.
- Хоригийн амны тоногдсон дурсгалуудыг сумын удирдлагууд, соёлын төвд хандаж ажлын хэсэг байгуулан газар дээр нь очиж баримтжуулсан байна. Авран хамгаалах ажлын хэсэгт Монголын үндэсний музей, АНУ Питсбургийн их сургууль, Америкийн монгол судлалын холбоо хамтран тоногдсон дурсгал дээр ажиллажээ.
- Хэнтий аймаг: Бөөр булгийн дурсгал, Хөшөөт чулуутын дөрвөлжин булш тоногдсоныг олж тогтоон сумын цагдаад мэдэгдсэн.

Хамгаалалтад авсан дурсгалын талаарх мэдээлэл Дорноговь, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн бүртгэл, мэдээллийн сангаас нийт 848 дурсгал хамгаалалтад авсан мэдээ байна. Үүнд,

- Сүхбаатар аймгийн Уулбаян суманд түүх, соёлын үл хөдлөх 309 дурсгалаа Сумын ИТХ-ын 2020.02.09 шийдвэрээр,
- Дорноговь аймгийн АИТХурлын шийдвэрээр Аймаг, нийслэл – 9, сум, дүүрэг – 9 дурсгал хамруулсан байна. Үүнд: Хатны булаг, Өлийн хийд, Цонжийн чулуу, Хан Баянзүрх хайрхан, Хамарын хийд, Эрээн-Уул, Дариатын булаг, бүсийн чулуу, Дунд баруун Мандал, суманд Анги Шагдарын дурсгалын багана, Туулай чулуу, Аймаг байгуулагдсан, газрын дурсгал, Улаан толгойн хөөврийн хурал, Саран хөөврийн хийдийн туурь, Бумбатын хийдийн туурь, Бөөрийн хийдийн туурь, Сүлдэнэ хөх овоо, Бурхант.
- Өвөрхангай аймгийн ИТХурлын 2018/06/27 07 тоотоор 530 дурсгал хамгаалалтанд авсан.

Хамгаалалтын хайс, хашаа барьсан тухай мэдээлэл Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Хөвсгөл аймгийн бүртгэл, мэдээллийн сангаас ирсэн ба нийт 104 дурсгалт газар хамгаалалтын хайс, хашааг дотоод нөөц бололцоогоороо хийж гүйцэтгэсэн байна.

Зураг 5



Дүгнэлт

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Аймаг, нийслэлийн 15 бүртгэл, мэдээллийн санд шинээр 843 дурсгал бүртгэгдсэн байна. Үл хөдлөх дурсгалын авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны зөвшөөрөлтэй 6 байгууллагын авран хамгаалах ажлаар 6 байгууллага 522 авран хамгаалах малтлага, эрдэм шинжилгээ судалгаагаар 985 газарт судалгаа явуулсан бөгөөд нийт 1859 дурсгалт газар ажиллажээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН 2019 ОНЫ ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 23.2-т заасны дагуу Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг боловсруулах хүснэгтийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 15-ны дотор цахимаар info@ncch.gov.mn хаягаар, цаасан хэлбэрээр Соёлын өвийн үндэсний төвийн албан ёсны шуудангийн хаягаар ирүүлэх тухай албан бичгийг 21 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Нийслэлийн соёл, урлагийн газарт 2020 оны 01 дүгээр сарын 9-нд хүргүүлсэн.

Тайланг дараах 4 төрлийн хүснэгт (хавсралт 1-4)-ээр авсан болно. Үүнд:

1. Хүснэгт №1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл
2. Хүснэгт №2 Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн
3. Хүснэгт №3 Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн
4. Хүснэгт №4 Соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн

Шинэчилсэн бүртгэлийн мэдээлэл боловсруулах хүснэгт болон БСШУС-ын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дугаар тушаалыг Соёлын өвийн үндэсний төвийн www.ncch.gov.mn вэб сайтын татах цэсний - мэргэжил арга зүй - Соёлын биет бус өв талбарын жагсаалтаас татаж авахаар оруулсан.

Тус хугацаанд ирүүлэх байсан 22 байгууллагаас 10 байгууллага ирүүлсэн ба 12 байгууллага тайланг ирүүлээгүй. Мэдээлэл ирүүлсэн 10 байгууллагаас Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн тайлан шаардлага хангаж, мэдээлэл, тоон дүнг бүрэн гүйцэд ирүүлсэн ба бусад аймгуудын тоон дүн зөрүүтэй, нэр томъёо буруу, мэдээлэл дутуу зэрэг нийтлэг алдаа дутагдалтай, шаардлага хангахгүй тайлан ирүүлсэн байна.

Хүснэгтийн дагуу ирүүлсэн мэдээллийг хянаж үзэхэд дараах алдаа дутагдал илэрсэн. Үүнд:

Хүснэгт №1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл: (13 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Эзэмшсэн өвийн нэр хэсэгт нэр томъёог буруу бичих, ай савын нэрээр бичих, 2 ба хэд хэдэн өвийг 1 хүнд хамаатуулж бичих, БСШУС-ын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дугаар тушаалд дурдсан өвийн нэр томъёог өөрчилж оруулах зэрэг нийтлэг дутагдал байна.
2. Регистрийн дугаарыг бичихгүй орхих, зөвхөн он сарыг бичих, үсэг дутуу бичих
3. Оршин суугаа хаягын мэдээлэл дутуу, шилжсэн тухай газрын нэр зөрөх, утасны дугаар бичигдээгүй, бүртгэгдсэн он бичигдээгүй, бүртгэлээс хассан шалтгаан ойлгомжгүй, давхардуулж бичих зэрэг нийтлэг алдаа дутагдал гарлаа.

Хүснэгт №2 Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн: (9 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Сум тус бүрийн мэдээлэл /тоон дүн/-ийг оруулаагүй,
2. Тоон дүн хүснэгт 3, 4-өөс зөрүүтэй,

Хүснэгт №3 Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн: (9 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Сум тус бүрийн мэдээлэл /тоон дүн/-ийг оруулаагүй,
2. Тоон дүн нь хүснэгт 1, 2, 4-өөс зөрүүтэй,
3. СӨУНБМС, аймаг, нийслэлийн СӨБМС-нд бүртгэгдсэн хүний хяналтын тоон дүн зөрүүтэй,

Хүснэгт №4 Соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн: (6 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Өвийн оноосон нэр хэсэгт нэр томъёог буруу бичих, ай савын нэрээр бичих, 2 ба хэд хэдэн өвийн нэрийг хамтад нь бичих, өвийн болон өвлөн уламжлагчийн тоон дүн зөрүүтэй,
2. Сум, дүүргийн тархалт бичигдээгүй, бичигдсэн сумын нэрс нь тоон дүнтэй зөрөх, УНБМС-нд ирүүлсэн хяналтын тоо зөрүүтэй зэрэг нийтлэг алдаа дутагдал гарсан.

Дээрх алдаа дутагдлыг залруулах зорилгоор Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг хүлээн авах хугацааг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хүртэл сунгаж холбогдох аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн, олон нутаг судлах музейн бүртгэл, мэдээллийн санч нарт мэйл хаяг болон утасаар арга зүйн зөвлөмж өгч албан бусаар мэдээллийг хүргүүлсэн.

2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс өмнө мэдээллийн алдаа дутагдлыг засварлан нийт 21 аймаг, нийслэлийн соёл, урлагийн газраас шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг ирүүлсэн байна. (Хавсралт 5.)

2020 оны байдлаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд анхан шатны байдлаар 10495 хүмүүс бүртгэгдсэн бөгөөд 2018-2019 онд 2446 хүн буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2020 онд хүснэгт 3-аар ирүүлсэн 21 аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоон дүнг нэгтгэн хүснэгт болон хувь, графикаар харуулав.

Хүснэгт 1

**Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2019 он байдлаар
бүртгэгдсэн Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн
бүртгэлийн нэгдсэн тоон дүн**

№	Аймаг, нийслэлийн нэр	Өвийн тоо	Аймаг, нийслэлийн СӨБМС-нд 2010-2017 онд бүртгэгдсэн хүний (хяналтын) тоо	2018-2019 оны баяжилтын тоо	Хасагдсан өвлөн уламжлагчийн тоо	Өвлөн уламжлагчийн нийт тоо
1	Архангай	35	231	149	3	377
2	Баян-Өлгий	105	404	237	20	621
3	Булган	31	177	18	0	195
4	Баянхонгор	65	133	178	24	287
5	Говь-Алтай	77	530	148	78	600
6	Говьсүмбэр	48	116	228	25	319
7	Дархан-Уул	28	74	7	6	75
8	Дорнод	87	273	92	43	322
9	Дорноговь	43	314	108	20	402
10	Дундговь	0	195	175	0	370
11	Завхан	72	473	109	74	508
12	Орхон	35	0	227	0	227
13	Өвөрхангай	55	169	109	15	263
14	Өмнөговь	65	236	85	16	305
15	Сүхбаатар	76	232	64	43	253
16	Сэлэнгэ	108	599	59	166	492
17	Төв	72	554	62	11	605
18	Увс	94	223	262	84	401
19	Ховд	111	265	692	33	924
20	Хөвсгөл	72	1060	163	318	905
21	Хэнтий	0	360	295	40	615
22	Улаанбаатар	0	1428	408	407	1429
	Нийт дүн		8046	3875	1426	10495

Зураг 1



Зураг 2



Нийт өвлөн уламжлагчдын 50% нь буюу 3635 хүн Ардын язгуур урлаг, 23% нь буюу 1685 хүн Уламжлалт гар урлал, 9% нь буюу 653 хүн Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, 9% нь буюу 635 хүн Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, 6% нь буюу 407 хүн Уламжлалт арга ухаан, 2% нь буюу 181 хүн Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2% нь буюу 141 хүн Мал маллах арга ухаан зэрэг ай савд хамаарагдаж байна.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд 2020 онд хүснэгт 2-оор ирүүлсэн 21 аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 7 ай савын тоон дүнг нэгтгэн хүснэгт болон графикаар харуулав.

Тус хүснэгтэд Булган аймаг сум тус бүрээр гаргаагүй, Дорнод аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Дундговь аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Орхон аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Хэнтий аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Улаанбаатар хотын дүүргүүдийн тоон дүн, нэр томъёог буруу оруулсан тул тоон дүнг нийт дүнгээр авч гаргав.

Хүснэгт 2

Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2019 оны байдлаар бүртгэгдсэн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын ай савын нэгдсэн тоон дүн:

№	Ай сав	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	Ардын язгуур урлаг	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Уламжлалт арга ухаан	Мал маллах арга ухаан	Уламжлалт гар урлал	Дүн
1	Архангай	33	119	65	8	43	5	104	377
2	Баян-Өлгий	74	242	68	16	71	8	142	621
3	Булган								195
4	Баянхонгор	34	105	53	8	24	3	60	287
5	Говь-Алтай	74	282	42	23	33	30	116	600
6	Говьсүмбэр	14	138	64	5	24	0	74	319
7	Дархан-Уул	8	53	1	1	1	0	11	75
8	Дорнод								322
9	Дорноговь	32	181	38	12	24	22	93	402
10	Дундговь								370
11	Завхан	47	211	12	5	23	0	210	508
12	Орхон								227
13	Өвөрхангай	18	106	49	4	10	0	76	263
14	Өмнөговь	40	122	26	2	6	2	107	305
15	Сүхбаатар	23	110	12	14	24	5	65	253
16	Сэлэнгэ	33	235	62	6	13	5	138	492
17	Төв	39	345	37	24	10	0	150	605
18	Увс	41	188	40	21	30	14	67	401
19	Ховд	49	595	45	18	52	45	120	924
20	Хөвсгөл	94	603	21	14	19	2	152	905

21	Хэнтий								615
22	Улаанбаатар								1429
	Нийт	653	3635	635	181	407	141	1685	10495

Зураг 3



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч нь нийт өвлөн уламжлагчийн 1 хувийг эзэлж байна.

Тус жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчдын 36 хүн нь үндсэн захиргаа буюу төрсөн нутагтаа амьдарч байна. Шилжилт хөдөлгөөн хийсэн нийт 49 хүний 43 нь Улаанбаатар хотруу, 2 хүн Ховд аймаг, 2 хүн Орхон аймаг, 1 хүн Сэлэнгэ аймаг, 1 хүн Ховд аймагт тус тус шилжэн суурьшсан бол 13 хүн нас барж, 4 хүний мэдээлэл илрээгүй үзүүлэлтэй байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3


“Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагчдын шилжилт хөдөлгөөний мэдээлэл.

Аймаг, нийслэлийн нэр	Одоо байгаа	Нас барсан	Шилжсэн	Шилжиж ирсэн	Үндсэн захиргаа	Мэдээлэлгүй
Архангай	1	1	1		3	
Баян-Өлгий	2	1	1		4	
Баянхонгор			4		6	2
Булган	1	1			2	
Говь-Алтай	1		1		3	1

Говьсүмбэр				2		
Дархан-Уул						
Дорноговь			1		1	
Дорнод	2		1		3	
Дундговь	4	2	6		12	
Завхан		1	4		5	
Өвөрхангай	2	1	5		8	
Өмнөговь	4	1	4		9	
Орхон				2		
Сүхбаатар		1	2		3	
Сэлэнгэ				1		
Төв		1	2		3	
Увс	6	1	6		13	
Ховд	8	1	7	1	16	
Хөвсгөл	1		3		5	1
Хэнтий	1	1	1		3	
Улаанбаатар	3			43	3	
	36	13	49	49	102	4

Зураг 4

Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авъяастны улсын жагсаалтад бүртгэгдсэн 102 хүнийг үндсэн захиргаагаар ангилсан байдал:



ДҮГНЭЛТ

Соёлын биет бус өвийн тухай бодлого ба зохицуулалт зарим улс орнуудад, ялангуяа Зүүн Азийн орнуудад 1950-иад оноос эхлэсэн бөгөөд манай орны хувьд ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцид 2005 онд нэгдсэнээр Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа идэвхижсэн боловч СББӨ, өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааны ажилд учир дутагдал байсаар байгаа нь энэхүү бүртгэлээс харагдаж байна.

2020 оны байдлаар соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд анхан шатны байдлаар 10495

авьяас билэгт хүмүүс бүртгэгдсэн бөгөөд 2018-2019 онд 2446 хүн буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт өвлөн уламжлагчдын 50% нь буюу 3635 хүн Ардын язгуур урлаг, 23% нь буюу 1685 хүн Уламжлалт гар урлал, 9% нь буюу 653 хүн Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, 9% нь буюу 635 хүн Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, 6% нь буюу 407 хүн Уламжлалт арга ухаан, 2% нь буюу 181 хүн Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2% нь буюу 141 хүн Мал маллах арга ухаан зэрэг ай савд хамаарч байна.

Тоон дүнгээс харахад ардын язгуур урлаг, уламжлалт гар урлалын ай саваас бусад илэрхийллүүд маш цөөн хувийг эзэлж байгаа нь тэдгээр өвийн олон төрөл зүйлс устаж үгүй болж буй, эсвэл тухайн өв болон уламжлагчийг олж илрүүлэх, таньж тогтоох судалгааны ажил хангалтгүй хийгдэж байгааг нотлон харуулж байна. Мөн тухайн аймаг, нийслэлийн соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн, бүртгэлийн ажилтны мэргэжлийн ур чадвар, тогтвор суурьшил, мөн өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааг хийх хүний нөөц, санхүү, төсвөөс шалтгаалан бүртгэлийн ажлын чанарт нөлөөлж болох юм.

Энэ удаагийн бүртгэл, судалгааны тайлангийн нэгтгэлийн хүснэгтүүд нь хоорондоо уялдаатай хийгдсэн ба тоон дүнг нэгтгэн гаргах, СББӨ-ийн албан ёсны нэр томъёог ашиглах, сум, дүүргийн тархалтын мэдээллийг гаргах зэрэг олон тоон үзүүлэлтийг нэгтгэн цаг хугацаанд нь бүрэн гүйцэд ирүүлсэн Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын сайн жишээг дурдах нь зүйтэй.

-оОо-

**..... аймаг/дүүргийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын
анхан шатны нэгдсэн бүртгэл**

Хүснэгт 1

№	Эзэмшсэн өвийн нэр	Хавсарсан өвийн нэр	Овог, нэр	Регистрийн дугаар	Төрсөн он	Хүйс	Яс үндэс	Үндсэн захиргаа	Одоогийн оршин суугаа хаяг /шилжсэн тухай тэмдэглэл/	Эрхэлж буй ажил	Утасны дугаар	Бүртгэгдсэн он	Бүртгэлээс хассан шалтгаан		
													Нас барсан /он бичих/	Шилжсэн /он бичнэ/	Бусад /шалтгааныг бичнэ/
1. Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд															
1															
2															
2. Ардын язгуур урлаг															
3															
4															
3. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам															
5															
6															
4. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл															
7															
8															
5. Уламжлалт арга ухаан															
9															
10															
6. Мал маллах арга ухаан															
11															
12															
7. Уламжлалт гар урлал															

13															
14															

Боловсруулсан: /овог, нэр, албан тушаал/
 оны ... сарын ... өдөр

Хавсралт 2

Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн

Хүснэгт №2

.....аймаг, нийслэл.									
№	Хамрагдсан сум, дүүргийн нэрс	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	Ардын язгуур урлаг	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Уламжлалт арга ухаан	Мал маллах арга ухаан	Уламжлалт гар урлал	Дүн
1									
2									
3									
	Нийт дүн								

Боловсруулсан: /овог, нэр, албан тушаал/
 оны ... сарын ... өдөр

**Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын
баяжилтын нэгдсэн тоон дүн**

Хүснэгт 3

..... аймаг, нийслэл									
№	Хамрагдсан сум, дүүргийн нэрс	2010-2017 онд СӨУНБМСанд явуулсан хяналтын тоо		2018-2019 онд аймаг, дүүргийн БМСанд бүртгэгдсэн баяжилтын тоо		Бүртгэлээс хасагдсан		Нийт дүн	
		Өвийн тоо	Өвлөн уламжлагчийн тоо	Өвийн тоо	Өвлөн уламжлагчийн тоо	Өвийн тоо	Хасагдсан өвлөн уламжлагчийн тоо	Өвийн тоо	Өвлөн уламжлагчийн тоо
1									
2									
3									
4									
	Нийт дүн								

Боловсруулсан: /овог, нэр, албан тушаал/

.... оны ... сарын ... өдөр

.... аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн

№	Ай сав	Өвийн оноосон нэр	Өвийн тоо	Өвлөн уламжлагчдын тоо	Өвийн тархалт	
					Илэрсэн сум, дүүргийн нэрс	Илэрсэн сум, дүүргийн тоо
1	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд					
2	Ардын язгуур урлаг					
3	Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам					
4	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл					
5	Уламжлалт арга ухаан					
6	Мал маллах арга ухаан					
7	Уламжлалт гар урлал					
Нийт дүн						

Боловсруулсан:

..... /овог, нэр, албан тушаал/

.... оны ... сарын ... өдөр

2019 оны соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн шинэчилсэн бүртгэлийн тайлан ирүүлсэн тухай мэдээ.

№	Аймаг, нийслэлийн нэрс	Цаасаар ирсэн /Огноо/	Цахимаар ирсэн /Огноо/	Тайлбар
1	Архангай	2020.II/13	2020.II/13	СББӨ-ийн тоо зөрүүтэй, Өвлөн уламжлагчийн мэдээлэл дутуу, БУСГ-ын мэргэжилтэнтэй холбогдож зөвлөмж өгсөн. 02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. (хүснэгт 2) БУСГ-ын мэргэжилтэн Октябрь 89002880
2	Баян-Өлгий	2020.II/14	2020.II/17	2 сарын 18-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. БУСГ-ын мэргэжилтэн Ермек 994288200
3	Баянхонгор	2020.II/13	2020.III/20	Хяналтын тоо зөрүүтэй (хүснэгт 2) музейн БМСанч Эрдэнэхуяг /99039064/
4	Булган	2020.III/6	2020.III/6	Музейн БМСанч Нарантуяа 99473626 газар, БУСГ-ын мэргэжилтэн Ууганчимэг 88343438
5	Говь-Алтай		2020.II/13	Тоо зөрүүтэй Музейн БМСанч Нэргүй 99933725, БУСГ-ын мэргэжилтэн Жаргалсайхан 99087762
6	Говьсүмбэр	2020.II/13	2020.II/13	Гарамсан БУСГ 99143342 тоо зөрүүтэй
7	Дархан-Уул	2020.II/7	2020.II/12	Мэдээллийг засварлах талаар зөвлөмж өгсөн. 02 сарын 17-нд мэдээллийг засварлаж ирүүлсэнч тоо зөрүүтэй Музейн БМСанч Г.Энхбаяр 99372046
8	Дорноговь	2020.II/17	2020.II/17	тоо зөрүүтэй Музейн БМСанч Уранжаргал 88617821
9	Дорнод	2020.II/14	2020.II/14	СББӨ-ийн тоо зөрүүтэй, Өвлөн уламжлагчийн мэдээлэл дутуу, БУСГ-ын мэргэжилтэн /Л.Идэрбат 99298082/-тэй холбогдож зөвлөмж өгсөн. 02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлэхээр болсон. Ирүүлээгүй.
10	Дундговь		2020.III/6	СББӨ, өвлөн уламжлагчдын тоо зөрүүтэй БУСГ-ын мэргэжилтэн Шинэбаяр 88669600, 95736969
11	Завхан	2020.II/29	2020.II/12	02 сарын 14-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч Ч.Мөнхзул 92030311
12	Орхон		2020.III/4	СББӨ, өвлөн уламжлагчдын тоо зөрүүтэй, засварлах шаардлагатай. Музейн БМС Гансоёмбо 99887731, БУСГ-ын мэргэжилтэн 99808927
13	Өвөрхангай		2020.II/17	02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч Гантулга 99902844
14	Өмнөговь	2020.II/12	2020.II/12	02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч 88694404

15	Сүхбаатар	2020.II/12	2020.II/12	02 сарын 15-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. БСУГ-ын газрын мэргэжилтэн Б.Золхүү 99518990
16	Сэлэнгэ	2020.II/14	2020.II/14	БСУГ-ын мэргэжилтэн Азжаргал
17	Төв	2020.II/11	2020.II/12	02 сарын 14-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч Д.Дагмидмаа 89692129
18	Увс	2020.III/2	2020.II/20	СББӨ, өвлөн уламжлагчдын тоо зөрүүтэй, байсан тул 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр БСУГ-ын газрын мэргэжилтэнтэй холбогдож мэдээллийг засварлах талаар зөвлөмж өгсөн. 03 сарын 04-нд ирүүлсэн. Оюунцэцэг БСУГ-ын мэргэжилтэн 95254809
19	Ховд		2020.II/14	02 сарын 21-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. БСУГ-ын мэргэжилтэн С.Алтангэрэл 99506975
20	Хөвсгөл		2020.II/20	тоо зөрүүтэй Баасансүрэн 99771162,
21	Хэнтий		2020.II/22	тоо зөрүүтэй Дэлгэрмаа 98707115
22	Нийслэл	2020.III/04	2020.II/20	тоо зөрүүтэй НСУГ-ын мэргэжилтэн Гомбосүрэн 96002773

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Улс, аймаг, байгууллагын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн баяжилт төрийн болон орон нутгийн өмчийн 32 музей, орон нутаг судлах танхим 104, орон нутгийн өмчийн бусад байгууллага 1, нийт **136** байгууллагад хийгдсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн 32 музей нийт 1109 дэсийн 1119 ширхэг, Орон нутаг судлах танхим нийтдээ 1119 дэсийн 116 ширхэг, орон нутгийн өмчийн 1 номын сан 5 дэсийн 5 ширхэг нийт **2233** дэсийн **3161** ширхэг дурсгалаар сан хөмрөгөө баяжуулсан байна.

Нэмэгдсэн үзмэрийн **11%** буюу 246 дэсийн 341 ширхэг үзмэрийг улсын болон орон нутгийн төсвөөс худалдаж авсан бол үлдсэн 89 %-ийг бэлэг хандив, шилжүүлэг, судалгаа шинжилгээ, бусад арга замаар авсан байна. Үүнээс манай музейнүүд үзмэрийн шаардлага хангасан чанартай үзмэрээр сан хөмрөгөө баяжуулж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд 4 аймгийн 123 хувь хүний 155 дэсийн 155 ширхэг эд өлгийн зүйлийг улсын бүртгэлд авсан байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөнд нийт 33 байгууллагын **4901** дэсийн **8704** ширхэг дурсгал хамрагдсан. Үүнээс, дотоодын үзэсгэлэнд 28 музейн 3423 дэсийн 5797 ширхэг үзмэр, гадаадын үзэсгэлэнд 4 байгууллагын 206 дэсийн 478 ширхэг үзмэр, судалгаа шинжилгээнд 10 музейн 1272 дэсийн 2066 ширхэг үзмэр, сэргээн засварлалтад 17 байгууллагын 147 дэсийн 363 ширхэг хамрагдсан байна.

ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монгол банкны Эрдэнэсийн сан, Ховд их сургуулийн тайлангаас харахад санд зааврын дагуу хувийн дугаар өгөгдөөгүй, цахим бүртгэлд оруулаагүй зэрэг асуудал нийтлэг байгааг анхаарах шаардлагатай байна.

Аймаг, нийслэлийн 15 бүртгэл, мэдээллийн санд шинээр 843 үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн байна. Үл хөдлөх дурсгалын авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны зөвшөөрөлтэй 6 байгууллагын авран хамгаалах ажлаар 6 байгууллага 522 авран хамгаалах малтлага, эрдэм шинжилгээ судалгаагаар 985 газарт судалгаа явуулсан бөгөөд нийт 1859 дурсгалт газар ажиллажээ.

Соёлын биет бус өвийн тухай бодлого ба зохицуулалт зарим улс орнуудад, ялангуяа Зүүн Азийн орнуудад 1950-иад оноос эхлэсэн бөгөөд манай орны хувьд ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцид 2005 онд нэгдсэнээр Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа идэвхижсэн боловч СББӨ, өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааны ажилд учир дутагдал байсаар байгаа нь энэхүү бүртгэлээс харагдаж байна.

2020 оны байдлаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд анхан шатны байдлаар 10495 хүн бүртгэгдсэн бөгөөд 2018-2019 онд 2446 хүн буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Анхан шатны байдлаар бүртгэгдсэн нийт өвлөн уламжлагчдын 50% нь буюу 3635 хүн Ардын язгуур урлаг, 23% нь буюу 1685 хүн Уламжлалт гар урлал, 9% нь буюу 653 хүн Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, 9% нь буюу 635 хүн Уламжлалт

баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, 6% нь буюу 407 хүн Уламжлалт арга ухаан, 2% нь буюу 181 хүн Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2% нь буюу 141 хүн Мал малллах арга ухаан зэрэг ай савд хамаарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч нь нийт өвлөн уламжлагчийн 1 хувийг эзэлж байна. Тус жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчдын 36 хүн нь үндсэн захиргаа буюу төрсөн нутагтаа амьдарч байна. Шилжилт хөдөлгөөн хийсэн нийт 49 хүний 43 нь Улаанбаатар хотруу, 2 хүн Ховд аймаг, 2 хүн Орхон аймаг, 1 хүн Сэлэнгэ аймаг, 1 хүн Ховд аймагт тус тус шилжэн суурьшсан бол 13 хүн нас барж, 4 хүний мэдээлэл илрээгүй үзүүлэлтэй байна.

Энэ удаагийн бүртгэл, судалгааны тайлангийн нэгтгэлийн хүснэгтүүд нь хоорондоо уялдаатай хийгдсэн ба тоон дүнг нэгтгэн гаргах, СББӨ-ийн албан ёсны нэр томъёог ашиглах, сум, дүүргийн тархалтын мэдээллийг гаргах зэрэг олон тоон үзүүлэлтийг нэгтгэн цаг хугацаанд нь бүрэн гүйцэд ирүүлсэн Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын сайн жишээг дурдах нь зүйтэй юм.

УНБМСанд ирүүлсэн тайланг нягтлан үзэхэд Орхон, Булган, Хэнтий, Дундговь, Нийслэлийн соёл урлагийн газар зэрэг байгууллагууд шаардлага хангахгүй мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд: Эзэмшсэн өвийн нэр хэсэгт нэр томъёог буруу бичих, ай савын нэрээр бичих, 2 ба хэд хэдэн өвийг 1 хүнд хамаатуулж бичих, БСШУС-ын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дугаар тушаалд дурдсан өвийн нэр томъёог өөрчилж оруулах, регистрийн дугаарыг бичихгүй орхих, зөвхөн он сарыг бичих, оршин суугаа хаягын мэдээлэл дутуу, шилжсэн тухай газрын нэр зөрөх, утасны дугаар, бүртгэгдсэн он бичигдээгүй, бүртгэлээс хассан шалтгаан ойлгомжгүй, давхардуулж бичих, сум тус бүрийн мэдээлэл /тоон дүн/-ийг оруулаагүй, тоон дүн нь бусад хүснэгтээс зөрүүтэй, сум, дүүргийн тархалт бичигдээгүй, бичигдсэн сумын нэрс нь тоон дүнтэй зөрөх гэх мэт нийтлэг алдаа дутагдалыг гаргасан байна.

Тоон дүнгээс харахад Ардын язгуур урлаг, Уламжлалт гар урлалын ай саваас бусад илэрхийллүүд маш цөөн хувийг эзэлж байгаа нь тэдгээр өвийн олон төрөл зүйлс устаж үгүй болж буй, эсвэл тухайн өв болон уламжлагчийг олж илрүүлэх, таньж тогтоох судалгааны ажил хангалтгүй хийгдэж байгааг нотлон харуулж байна. Мөн тухайн аймаг, нийслэлийн соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн, бүртгэлийн ажилтны мэргэжлийн ур чадвар, тогтвор сууршил, мөн бүртгэл, судалгааны ажлыг хийх хүний нөөц, санхүү, төсвөөс шалтгаалан бүртгэлийн ажлын чанарт нөлөөлж болох юм.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ САНАЛ

1. Соёлын өвийг хадгалж, бүртгэж байгаа байгууллагууд бүртгэл, мэдээллийн санч болон холбогдох мэргэжилтнүүдээ бүртгэл, мэдээллийн сангийн сурталтад тогтмол хамруулж байх,
2. СББӨ, өвлөн уламжлагчийн судалгааны асуулга, мэдээллийг илүү баяжуулах зорилгоор, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 541 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийн маягыг шинэчлэн сайжруулах,
3. Нийслэлийн соёл, урлагийн газар, Шинжлэх ухааны академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, Их дээд сургууль, бусад түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж байгаа байгууллагуудын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжуулах,
4. Түүх, соёлын үл хөдлөх “дурсгал”, “дурсгалт газар”-ын талаарх нэгдмэл ойлголтыг бий болгох, мэдээллийг үнэн зөв гаргах үүднээс мэргэжлийн судалгаа шинжилгээний байгууллагуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.

-оОо-

ТАЙЛАН БИЧСЭН:

Ш.ЭНХТУЯА. /СӨБСГ-ын Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч/

Ж.НАСАНЖАРГАЛ /СӨБСГ-ын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч/

Г.БҮРЭНТӨГС. /СӨБСГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч/

ХЯНАСАН:

Г.ЭНХБАТ /Соёлын өвийн үндэсний төвийн захирал/